

Огноо: 2023.03.17

№ 42

Улаанбаатар хот

**Төрийн банкны 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд дүгнэлт өгөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10.13.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2022 оны бизнес болон санхүүгийн төлөвлөгөөний зорилтот түвшин хангагдсан гэж дүгнэсүгэй.
2. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад дараах арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай. Үүнд:

2.1. “Төрийн банк” ХК-ийн актив пассивын зохистой удирдлагыг хангах, татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, банкны өдөр тутмын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтын өндөр түвшинд ханган ажиллаж, төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад анхаарах;

2.2. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан цахим шилжилт хийх, программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлын явцыг эрчимжүүлж, мэргэшсэн боловсон хүчний нөөц болон чадавхыг нэмэгдүүлэх;

2.3. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан чанаргүй зээлийг зорилтот түвшинд барьж ажиллах.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны ажлын тайлан, Төрийн банкны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулж хэлэлцүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Б.Тэлмүүн/-д тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН